



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК

Захирал Г.Саранчимэг

Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Аудитор: О.Мандах

Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



БААЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.НАСАНБАЯР ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

ААН. 02.23 № 2/42

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд улсын төсвөөс 1,089,368.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,000,924,7 мянган төгрөгийг зарцуулж 2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 88,444.1 мянган төгрөг байсан бол орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 153,318.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч гүйцэтгэлээр 153,318.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар улирлын үр дүнгийн урамшууллын хувь буруу тооцсон, цахим дата хэрэглээний зардлыг

5020040

журмын дагуу зарцуулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гарсан боловч илэрсэн зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг алдааны түвшнээс бага байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай тайлагнасныг 89.2 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,921,333.92	158,334,776.71
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,777,884.11	88,444,110.45
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,777,884.11	88,444,110.45
31210	Төгрөг	6,777,884.11	88,444,110.45
31211	Төрийн сангийн харилцах	6,777,884.11	88,444,110.45
33	АВЛАГА	220,000.00	139,632.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	220,000.00	139,632.72
35	БАРАА МАТЕРИАЛ	67,923,449.81	69,751,033.54
35100	Түүхий эд материал	21,868,646.00	21,868,646.00
35110	Тусгай зориулалттай материал	21,468,646.00	21,468,646.00
35130	Эм боох материал	400,000.00	400,000.00
35400	Хангамжийн материал	46,054,803.81	47,882,387.54
35410	Бичиг хэргийн материал	762,910.00	786,410.00
35420	Аж ахуйн материал	45,291,893.81	42,258,693.81
35470	Бусад хангамжийн материал	0	4,837,283.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,606,348,970.74	1,634,907,550.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,606,348,970.74	1,634,907,550.50
39200	Биет хөрөнгө	1,564,152,970.74	1,592,711,550.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,581,697,713.99	1,581,697,713.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-247,312,808.65	-308,444,707.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,836,434.00	0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,390,335.96	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	258,606,335.47	337,929,036.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-120,653,579.22	-133,893,466.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,197,238.46	176,047,006.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-103,170,871.75	-86,576,538.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,336,540.00	9,336,540.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,104,105.60	-4,754,444.58
39217	Ном	21,110,410.00	21,370,410.00
39300	Биет бус хөрөнгө	42,196,000.00	42,196,000.00
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,196,000.00	42,196,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,681,270,304.66	1,793,242,327.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	582,962.00	373,594.23

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	582,962.00	373,594.23
41300	Өглөг	582,962.00	373,594.23
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	525,812.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	316,594.23
41360	Бусад өглөг	57,150.00	57,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	57,150.00	57,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,680,687,342.66	1,792,868,732.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,680,687,342.66	1,792,868,732.98
51100	Засгийн газрын оруулсан капитал	741,411,629.90	741,411,629.90
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	741,411,629.90	741,411,629.90
51200	Хуримтлагдсан үр дүн	193,566,897.62	305,748,287.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,489,773,834.04	193,566,897.62
51220	Тайлант үеийн үр дүн	1,683,340,731.66	112,181,390.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	745,708,815.14	745,708,815.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,681,270,304.66	1,793,242,327.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,717,247,356.01	1,398,049,047.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,766,723,456.01	155,362,047.33
120	Нийтлэг татварын бус орлого	1,766,723,456.01	155,362,047.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,549,000.00	4,641,920.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,549,000.00	786,920.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	3,855,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,689,067,667.20	145,882,843.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	76,106,788.81	4,837,283.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	950,523,900.00	1,242,687,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	786,612,000.00	1,089,368,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	786,612,000.00	1,089,368,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,911,900.00	153,318,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,911,900.00	153,318,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,033,906,624.35	1,270,963,380.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,033,906,624.35	1,270,963,380.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,004,747,871.22	1,220,907,140.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,298,466.00	747,099,123.03
210101	Үндсэн цалин	433,041,722.00	512,135,349.04
210102	Нэмэгдэл	121,441,107.00	192,696,060.88

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	8,758,400.00
210104	Урамшуулал	23,038,432.00	33,509,313.11
210105	Гэрээт ажлын хөлс	30,777,205.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,923,709.26	92,175,513.39
210201	Тэтгэврийн даатгал	55,575,291.26	63,839,935.23
210202	Тэтгэмжийн даатгал	5,837,105.00	7,462,523.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,669,683.00	5,970,018.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,167,421.00	1,353,663.52
210205	Эрүүл мэндийн даатгал	11,674,209.00	13,549,373.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,099,560.00	148,634,694.23
210301	Гэрэл, цахилгаан	23,992,010.00	9,714,694.23
210302	Түлш, халаалт	100,095,050.00	137,270,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,012,500.00	1,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,831,912.00	26,998,385.00
210401	Бичиг хэрэг	4,749,610.00	3,623,200.00
210402	Тээвэр, шатахуун	641,702.00	3,294,985.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,420,600.00	20,080,200.00
2105	Нормативт зардал	43,329,187.50	48,931,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,500.00	0
210502	Хоол, хүнс	42,218,887.50	48,931,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,099,800.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,025,150.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	8,025,150.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,390,000.00	2,788,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,549,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,841,000.00	2,788,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,849,886.46	149,279,825.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,072,240.00	13,167,837.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,832,950.00	7,512,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,944,696.46	128,599,987.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,158,753.13	50,056,240.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,812,000.00	50,056,240.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,812,000.00	36,304,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	13,751,740.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,346,753.13	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,346,753.13	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,683,340,731.66	127,085,666.65
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	14,904,276.33
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	14,904,276.33
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,683,340,731.66	112,181,390.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	952,072,900.00	1,247,328,920.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,549,000.00	4,641,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,549,000.00	4,641,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,549,000.00	4,641,920.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,549,000.00	786,920.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	3,855,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	950,523,900.00	1,242,687,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	786,612,000.00	1,089,368,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	786,612,000.00	1,089,368,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,911,900.00	153,318,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,911,900.00	153,318,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	918,063,015.89	1,139,482,693.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	918,063,015.89	1,139,482,693.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,683,762.76	1,088,252,393.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	611,803,478.01	747,404,935.03
210101	Үндсэн цалин	436,546,734.01	512,441,161.04
210102	Нэмэгдэл	121,441,107.00	192,696,060.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	8,758,400.00
210104	Урамшуулал	23,038,432.00	33,509,313.11
210105	Гэрээт ажлын хөлс	30,777,205.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,070,885.25	92,315,146.11
210201	Тэтгэврийн даатгал	53,420,124.41	63,889,200.46
210202	Тэтгэмжийн даатгал	5,680,011.77	7,473,746.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,041,785.41	6,024,471.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,064,431.22	1,355,908.06
210205	Эрүүл мэндийн даатгал	9,864,532.44	13,571,820.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,579,560.00	148,318,100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,292,800.00	9,398,100.00
210302	Түлш, халаалт	116,794,260.00	137,270,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,492,500.00	1,650,000.00
2105	Нормативт зардал	29,998,387.50	48,931,600.00
210502	Хоол, хүнс	29,998,387.50	48,931,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,380,000.00	5,813,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,549,000.00	774,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,831,000.00	5,039,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,851,452.00	40,468,712.52

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,971,302.00	32,417,712.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,880,150.00	8,051,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,379,253.13	51,230,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,032,500.00	51,230,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,032,500.00	36,304,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	14,925,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,346,753.13	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,346,753.13	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,009,884.11	107,846,226.34
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,232,000.00	26,180,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,232,000.00	26,180,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,232,000.00	26,180,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,232,000.00	26,180,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-27,232,000.00	-26,180,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,777,884.11	81,666,226.34
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	6,777,884.11
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,777,884.11	88,444,110.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	741,411,629.90	745,708,815.14	193,566,897.62	1,680,687,342.66
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	741,411,629.90	745,708,815.14	193,566,897.62	1,680,687,342.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	741,411,629.90	745,708,815.14	193,566,897.62	1,680,687,342.66
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	112,181,390.32	112,181,390.32
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	741,411,629.90	745,708,815.14	305,748,287.94	1,792,868,732.98



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,777,884.11	6,777,884.11	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,254,094,200.00	1,165,662,693.66	-88,431,506.34	92.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,254,094,200.00	1,165,662,693.66	-88,431,506.34	92.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,197,150,000.00	1,114,432,393.66	-82,717,606.34	93.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	817,284,200.00	747,404,935.03	-69,879,264.97	91.4
210101	Үндсэн цалин	559,285,800.00	512,441,161.04	-46,844,638.96	91.6
210102	Нэмэгдэл	221,259,900.00	192,696,060.88	-28,563,839.12	87.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	8,758,400.00	8,758,400.00	
210104	Урамшуулал	36,738,500.00	33,509,313.11	-3,229,186.89	91.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,160,900.00	92,315,146.11	-9,845,753.89	90.4
210201	Тэтгэврийн даатгал	69,469,500.00	63,889,200.46	-5,580,299.54	92.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,172,800.00	7,473,746.25	-699,053.75	91.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,538,400.00	6,024,471.07	-513,928.93	92.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,634,500.00	1,355,908.06	-278,591.94	83.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,345,700.00	13,571,820.27	-2,773,879.73	83.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,318,100.00	148,318,100.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,244,800.00	9,398,100.00	153,300.00	101.7
210302	Түлш, халаалт	137,273,300.00	137,270,000.00	-3,300.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,650,000.00	-150,000.00	91.7
2105	Норматив зардал	51,886,900.00	48,931,600.00	-2,955,300.00	94.3
210502	Хоол, хүнс	51,886,900.00	48,931,600.00	-2,955,300.00	94.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,514,900.00	6,513,900.00	-1,000.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	774,200.00	774,200.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,740,700.00	5,739,700.00	-1,000.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,985,000.00	65,948,712.52	(36,287.48)	99.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,374,000.00	57,337,712.52	-36,287.48	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,611,000.00	8,611,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,944,200.00	51,230,300.00	(5,713,900.00)	89.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,944,200.00	51,230,300.00	-5,713,900.00	90.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,018,400.00	36,304,500.00	-5,713,900.00	86.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,925,800.00	14,925,800.00	0.00	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,254,094,200.00	1,247,316,200.00	-6,778,000.00	99.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,089,368,900.00	1,089,368,900.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,089,368,900.00	1,089,368,900.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	153,318,100.00	153,318,100.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	153,318,100.00	153,318,100.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,407,200.00	4,629,200.00	-6,778,000.00	40.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,629,200.00	4,629,200.00	0.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,778,000.00	00.00	-6,778,000.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	6,777,884.11	6,777,884.11	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	88,444,110.45	88,444,110.45	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	47.00	43.00	-4.00	91.5
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	06.00	-4.00	60.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	333	333	0	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	333	333	0	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	333	333	0	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургууль нь “Танин мэдэхүйн хөгжлийг дэмжиж, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, хичээл бүрийг чанартай зохион байгуулан сурагчдыг хөгжүүлэх олон талт үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд: 1. сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

2. Сурагчдын оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах.

3. Багшийн хөгжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, хичээл бүрийг чанартай зохион байгуулах, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн ажиллах.

4. сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг сайжруулах, хэрэгжүүлэх хүнсний аюулгүй байдал халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн шим тэжээл сайтай хоол хүнсээр үйлчлэх.

5. Тоглонгоо суралцах аргад багш нарыг чадваржуулах, зөвлөх багш ажиллуулах” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 46 орон тоотой, 333 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Г.Насанбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Номингэрэл нар зурж, нярваар Ж.Батцэнгэл нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд тус бичиг баримт нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,972.0 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,777.80	88,444.10	81,666.30
Авлага	220.0	139.6	-80.40
Бараа материал	67,923.40	69,751.00	1,827.60
Үндсэн хөрөнгө	2,096,280.60	2,168,876.70	72,596.10
Хуримтлагдсан элэгдэл	-489,931.70	-533,969.10	-44,037.40
Нийт хөрөнгө	1,681,270.30	1,793,242.30	111,972.00
Өр төлбөр	582.9	373.5	-209.40
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,680,687.30	1,792,868.70	112,181.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,681,270.30	1,793,242.30	111,972.00

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баацагаан сумын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 81,666.3 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны төсөв захирагчаас тайлант хугацааны эцэст нэмэлт санхүүжилт орж ирсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 80.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх ажилчидтай холбоотой авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл нь өмнөх оноос 69,751.0 мянган төгрөг болж 1,827.6 мянган төгрөгөөр өссөн нь түрээсийн сурах бичгийг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 2,168,876.7 мянган төгрөг болж 72,596.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 560.0 мянган төгрөгийн үнэ бүхий принтер, 700.0 мянган төгрөгөөр wifi сүлжээ сайжруулагч, 7,500.0 мянган төгрөгөөр шалгалтын хариу засагч, нөхөн хангалтын зардлын санхүүжилтээр 20 ширхэг таблет 26,180.0 мянган төгрөгөөр тус тус бэлтгэн данс бүртгэлд тусгасан байна. БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар дижитал ангийн орчин бүрдүүлэлт 98,587.0 мянган төгрөг, давхар ор 1,900.0 мянган төгрөг, угаалгын машин 469.9 мянган төгрөг, хөлдөөгч 2,082.5 мянган төгрөг, багш сандал 270.0 мянган төгрөг, chromebook 3,545.7 мянган төгрөг, ангийн самбар 2,440.0 мянган төгрөг, багш ширээ 2,600.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр лингафоны танхим 26,928.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэн данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 тоот тогтоолоор 33,306.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 68,630.3 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А\147 дугаар тогтоолоор 30,836.4 мянган төгрөгийн 27-53БНА улсын дугаартай фургон маркийн тээврийн хэрэгслийг тус тус акталж данс бүртгэлээс хассан байна.

Өглөг дансны дансны үлдэгдэл 373.5 мянган төгрөг болж 209.3 мянган төгрөгөөр буурсан нь ХАОАТ-ын өглөг барагдуулж дууссан ба гэрэл цахилгааны зардалд 316.5 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.



3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,320,995.3 мянга, орон нутгийн төсвөөс 182,703.0 төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 33,384.8 мянган төгрөгөөр бууруулж 1,470,313.5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,100,776.1 мянган төгрөг болгож 369,537.4 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Энэ нь сургуулийн суралцагчдын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байгаатай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80111, 80226, 80312, 81605, 81801, 81806, 81816, 81823, 81834, 81835, 81848, 81844, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,503,698.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,320,995.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 182,703.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,089,368.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 153,318.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 923,900.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 153,318.1 мянган төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант оны эцэст 88,444.1 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,165,662.6 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 88,444.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Код	Хөтөлбөр арга хэмжээний нэр	/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,321.90	2,309.90	12.00	99.5
2	80312	Сургалт семинар	1,164.60	1,163.35	1.25	99.9
3	81605	Эрүүл мэндийг дэмжих	2,300.20	2,300.00	0.20	100.0
4	81801	үдийн цай хөтөлбөр	42,018.40	36,304.50	5,713.90	86.4
5	81806	Дотуур байрны үйлчилгээ	76693.8	66474.5231	10,219.28	86.7
6	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	24,164.90	24,158.00	6.90	100.0
7	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,168.80	5,168.40	0.40	100.0
8	81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	9660.1	6213.7472	3,446.35	64.3
9	81834	Боловсролын стандарт хангах	725348.1	664107.58	61,240.51	91.6
10	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	207306.1	199515.6883	7,790.41	96.2
11	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	105.00	104.70	0.30	99.7
12	81848	Сурах бичгийн түрээс	774.20	774.20	0.00	100.0
13	83602	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	3,750.00	3,750.00	0.00	100.0
Нийт			1,100,776.10	1,012,344.59	88,431.51	92.0

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 42,018.4 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны 51,886.9 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдаж зардал бүрд 3 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан Гэрэлт мөнх ундарга ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэлээр 36,304.5 мянган төгрөгийн үдийн цайны хүнсний материал, 48,931.6 мянган төгрөгийн дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 26,180.0 мянган төгрөгийн 20 ширхэг таблет худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 835,294.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,352.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 6,264.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,244,887.7 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 901,254.1 мянган төгрөгийн 22 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 12 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

	Мэдээлэл байршуулах хугацаа	Мэдээллийн		Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Мэдээлээгүй	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Зөрүү
		төрөл	тоо						
1	Сар бүр байршуулах	4	48	48	46	-	2	-	-
2	Хагас жилээр байршуулах	4	4	4	4	-	-	-	-
3	Жил бүр байршуулах	11	11	11	8	-	-	3	-
4	тухай бүр байршуулах	8	96	96	96	-	-	-	-
	Дүн	27	159	159	154	0	2		0

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж аудитаар 3,651.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,662.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1,610.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,662.5	2	1,662.5	100
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	1,610.0	3	1,610.0	100.0
Нийт дүн	3	3,272.5	3	3,272.5	100.0

Эх сурвалж: Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.05.18-ны өдрийн 43 дугаар албан бичиг



Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.18-ий өдөр 43 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,300.0 мянган төгрөгийн зөрчил илэрснийг дахин давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Багш нарын шүдний эмчилгээнд зориулан 2,300.0 мянган төгрөгийн эрүүл мэндийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, БШУС, ЭМС-ын хамтарсан 2022.06.29-ний өдрийн А/238,А/340 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид хологдох хууль, журмыг мөрдөн ажиллаж төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Багш нарын шүдний эмчилгээнд зориулан 2,300.0 мянган төгрөгийн эрүүл мэндийн зардлаас зарцуулсан байна.	1	2,300.0	0	0	1	2,300.0	0	0	0	0	0	0
	Нийт дүн	2	2,300.0	0	0	1	2,300.0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
		0						
Дүн		0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0					1	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 93/14210573/БНА/2024
/111/НА-СМА-Т243

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багш нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд Ганзүү уламжлалт эмчилгээний байгууллагатай гэрээ байгуулж, журмын зориулалт бусаар 2,300,000.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/238, А/340 "Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тушаалын заалтууд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/238, А/340 тоот тушаалд заасан үзлэг оношилгоонд ажилчдыг хамруулж байх, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05


5040173

05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг хүрээнд Баацагаан сумын сургуулийн захирал Г.Насанбаяр, нягтлан бодогч А.Номингэрэл нарт даалгав².


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН

АУДИТОР:  О.МАНДАХ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно